

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД,  
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД БОЛОН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны ... сарын .... өдөр

Дугаар\_\_\_\_\_

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

нэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

ЦАХИМ ХӨГЖИЛ,  
ИННОВАЦ, ХАРИЛЦАА  
ХОЛБООНЫ САЙД

Ц.БААТАРХҮҮ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны,  
Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон Хууль зүй, дотоод  
хэргийн сайд нарын хамтарсан тушаалын хавсралт

## **ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ ХОРИОТОЙ<sup>1</sup> БОЛОН ХҮҮХДЭД ХОРТОЙ<sup>2</sup> АГУУЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь Хүүхэд хамгааллын тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 25.11 дэх хэсэгт заасны дагуу цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг нарийвчлан зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг аливаа хүн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3. Хуулийн 25.12-т заасан орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн бүрэлдэхүүнд хамаарах Боловсролын, Эрүүл мэндийн, Хууль зүй, дотоод хэргийн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх төсвийг хуулийн 52.6-д заасны дагуу жил бүрийн төсөвтөө тусган энэхүү журмын хэрэгжилтийг хангуулахад хамтран ажиллана.

1.4. Тус журмаар зохицуулаагүй харилцаанд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

### **Хоёр. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа**

2.1. Цахим орчинд мэдээлэл байршуулж буй аливаа этгээд нь Хүүхэд хамгааллын тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг нягталж, хүүхдэд хортой болон хориотой агуулгыг нийтлэхгүй. Ийнхүү нягтлахдаа Зөвлөлөөс баталсан шалгуур үзүүлэлтийг ашиглаж болно.

2.2. Цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд учирч болох эрсдэлийг ойлгож, хамгаалах зорилгоор олон нийтэд түгээхийн өмнө контентын эрсдэлийг үнэлнэ. Эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

2.2.1. хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох эрсдэл;

2.2.2. хүүхдийн зураг, дуу, дуу-дүрсний бичлэг агуулсан контент, мэдээ, мэдээлэл, бүтээл бол хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл авсан эсэх;

<sup>1</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.15. "хориотой агуулга" гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

<sup>2</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.16. "хүүхдэд хортой агуулга" гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг.

2.2.3. хүүхэд, залуусын сэтгэхүй, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх эрсдэл;

2.2.4. хүүхдийн эрүүл мэнд, бие махбодод сөргөөр нөлөөлөх агуулга байх эрсдэл;

2.2.5. хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан эсэх;

2.2.6.гэмт хэргийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан эсэх;

2.2.7.мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хэрэглэхийг аргачлан заах, тэдгээрийн хууль бус эргэлт, хэрэглээг сурталчилсан, бэлтгэн боловсруулах, хэрэглэхийг харуулсан эсэх.

2.3.Цахим орчны үйлчилгээ эрхлэгч<sup>3</sup> нь энэ журмын 2.2-т дурдсан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар урьдчилан сэргийлнэ:

2.3.1.хүүхдэд эрсдэлтэй байж болзошгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах;

2.3.2.тухайн контентод агуулсан эрсдэлтэй хэсгийг засварлах;

2.3.3.контентыг зассаны дараа дахин үнэлгээ хийх;

2.3.4.шаардлагатай гэж үзвэл Зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах.

2.4. Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалахад эцэг, эх, асран хамгаалагч дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.4.1.цахим орчинд хүүхэд хамгааллын талаар өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, сургалтад хамрагдах;

2.4.2. хүүхдээ цахим орчинд нэвтрэхэд насны онцлогт тохирсон хяналт тавьж, шаардлагатай хязгаарлалт тогтоох;

2.4.3. шаардлагатай тохиолдолд мэргэжлийн этгээдээс зөвлөгөө, туслалцаа авах;

2.4.4. хүүхдийн ашиглаж буй үүрэн холбооны дугаарыг хүүхдийн нэр, насыг үнэн зөвөөр бүртгүүлж, ашиглуулах;

2.4.5. гэртээ ашиглаж буй интернэт, хүүхдийн ашиглаж буй ухаалаг төхөөрөмжийн эцэг эхийн хяналтын горимыг идэвхжүүлэх.

2.5.Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд боловсролын сургалтын байгууллага дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.5.1.цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг улирал бүр зохион байгуулах;

2.5.2.сургуулийн болон дотуур байрны орчинд ашиглаж буй интернэтийг 18+ контентын шүүлтүүртэй байхаар интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй хийх гэрээнд тусгаж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.3.багш, ажилтан, суралцагчид цахим орчинд нөхөрсөг бус харилцсан, маргаан, зөрчил гаргасныг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэх зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.5.4.сургуулийн орчинд интернэтийн хэрэглээнд хяналт тавих дотоод журмыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.6. Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд интернэтийн үйлчилгээ үзүүлж буй этгээд дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

<sup>3</sup> Хүүхэд хамгааллын тухай хууль. "цахим орчны үйлчилгээ эрхлэгч" гэж цахим хуудас, цахим хэрэглүүр /аппликэйшн/, платформ, цахим орчин ашиглаж контент, бүтээлийг олон нийтэд хүргэх үйлчилгээ үзүүлэгч этгээдийг ойлгоно.

2.6.1. хүүхэдтэй айл өрхөд үйлчилгээ үзүүлэхдээ 18+ контентын шүүлтүүртэй байх боломжийг бүрдүүлэх, заавар зөвлөмжөөр хангах;

2.6.2. хүүхдийн нэр дээр бүртгэгдсэн үүрэн холбооны дугаарын ашиглах интернэтийн үйлчилгээ нь 18+ контентын шүүлтүүртэй байх боломжийг бүрдүүлэх;

2.6.3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.6-д заасан арга хэмжээг авах технологийн боломжийг бүрдүүлсэн байх.

2.7. Хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэхэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.2-т заасан байгууллага дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.7.1. Хүүхэд хамгааллын тухай хууль болон энэ журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор цахим орчинд хүүхэд хамгаалах үүрэг хүлээсэн этгээдийн төрөл, онцлогт тохирсон заавар, зөвлөмж, гарын авлага гаргаж, олон нийтэд түгээх;

2.7.2. Энэхүү журмын 2.7.1-д заасан заавар, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, санал дүгнэлт гарган холбогдох байгууллагыг зөвлөмжөөр хангах;

2.7.3. цахим орчинд хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдох олон улсын байгууллага, үндэстэн дамнасан платформ, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлж, сайн туршлагыг нэвтрүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

2.7.4. цахим орчинд хүүхэд хамгаалахад оролцогч талуудад сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.7.5. Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

2.8. Хуулийн этгээд нь хуулийн 14.4, 52.7-д заасан сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахдаа цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар заавар, зөвлөмжийг өөрийн ажилтан, албан хаагчдад таниулна.

### **Гурав. Хамгаалах үйл ажиллагаа**

3.1. Цахим орчинд түгээсэн хориотой болон хүүхдэд хортой агуулгаас хамгаалах үйл ажиллагаанд цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, асуудлыг таних, илрүүлэх, мэдээлэх, бүртгэх, шалгах улмаар хариу арга хэмжээ авч ажиллах, түүнд хамтран ажиллах механизм, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон.

3.2. Хүн, хуулийн этгээд цахим орчинд хориотой болон хүүхдэд хортой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл үүссэн, эсхүл цахим орчин ашиглан хүүхдийг дарамталсан, урхидсан байж болзошгүй тохиолдолд хүүхдийн тусламжийн 108 дугаар, хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллага, Зөвлөлд бичгээр болон цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

3.3. Энэхүү журмын 3.2-т заасны дагуу мэдээлэл хүлээн авсан этгээд гомдол, мэдээллийн бүртгэл хөтөлж, холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 24 цагийн дотор шилжүүлнэ. Энэхүү журмын 3.2-т заасан хүүхдэд хортой агуулга эсэх талаарх дүгнэлтийг Зөвлөл тодорхойлж, холбогдох арга хэмжээг авна.

3.4. Гомдол, мэдээллийг хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан үзээд хориотой болон хүүхдэд хортой агуулга бүхий контентыг нийтэлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах бөгөөд дараах шаардлага хангасан шийдвэр, дүгнэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлнэ:

3.4.1. шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр, хаяг, эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байх ба албан бичгийн огноо, дугаарыг тодорхой заасан байх;

3.4.2. шийдвэр гаргасан шалтгаан, нөхцөл байдал, үндэслэл болон хэрэгжүүлэх технологийн арга хэмжээг тодорхой тусгасан байх;

3.4.3. хориотой болон хүүхдэд хортой агуулга бүхий контент, зар сурталчилгаа, мэдээ, мэдээллийг байршуулсан цахим хаяг, цахим холбоос, хэвлэмэл баримт зэрэг шаардлагатай баримтыг хавсаргах.

3.5. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 3.4-т заасан шийдвэр бүхий албан бичгийн дагуу дараах арга хэмжээг авах талаар цахим орчны үйлчилгээ эрхлэгчид нэн даруй мэдэгдэнэ:

3.5.1. шийдвэрт дурдсан контентыг устгах, эсхүл хандалтыг хаах, эсхүл түр хязгаарлах;

3.5.2. шийдвэрт дурдсан цахим хаяг, цахим хуудасны Монгол улсаас хандах хандалтыг зөрчил арилгах хүртэл хугацаанд хязгаарлах.

3.6. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 3.5-д заасан мэдэгдлийг тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин дахь хаяг эсхүл Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгэлтэй цахим шуудангаар хүргүүлснээр мэдэгдсэнд тооцно.

3.7. Зөрчил гаргасан цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 3.5-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд нэн даруй хэрэгжүүлж, хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

3.8. Цахим орчны үйлчилгээ эрхлэгчийг олж тогтоох боломжгүй эсхүл энэ журмын 3.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо дараах мэдэгдлийг цахим орчны үйлчилгээ эрхлэгч, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгчид хүргүүлнэ:

3.8.1. тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд хязгаарлах;

3.8.2. шийдвэрт дурдсан хориотой болон хүүхдэд хортой агуулга бүхий контентыг устгах, эсхүл хандалтыг хязгаарлах.

3.9. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч болон цахим орчны үйлчилгээ эрхлэгч нь энэ журмын 3.8-д заасан мэдэгдэлд дурдсан арга хэмжээг заасан хугацаанд нэн даруй хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд хэрэгжилтийн талаарх мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хороонд цахим шуудан, утсаар мэдэгдэж, албан бичгээр хүргүүлнэ.

3.10. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ журмын 3.3-д заасан эрх бүхий байгууллагаас цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн зөрчил арилсан талаарх шийдвэрийг ирүүлсэн тохиолдолд хандалтыг сэргээх технологийн арга хэмжээг нэн даруй авна.

## **Дөрөв. Бусад**

4.1. Энэхүү журмын хүрээнд гомдол, мэдээлэл хүлээн авсан, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгууллага нь хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг жил бүрийн эхний улиралд багтаан Хүүхдийн хөгжил, хамгааллын

салбар дундын ажлын хэсэгт хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

4.2. Хүүхдийн хөгжил, хамгааллын салбар дундын ажлын хэсэг нь жилийн нэгдсэн гаргаж олон нийтэд мэдээлэх бөгөөд цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн салбар бүрийн оролцоог тодорхойлж, санхүүжилтийг төлөвлөнө.

### **Тав. Хариуцлага**

5.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

ТӨСӨЛ